



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аймгийн Музейн 2016 оны 12 дугаар сарын 31-нээр
дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан

Аудитын код: БӨА-2017/53/СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

Цахим хуудас: bayanulgii@audit.gov.mn

Тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 99417382

Цахим хаяг: mhkuangan@yahoo.com

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930, 99932710

Цахим хаяг: kh_jenisbek@yahoo.com

Ахлах аудитор: Х.Еркебулан

Утас: 70423073

Цахим хаяг: akon_erka@yahoo.com

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	4
2.1	Оршил	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	8
2.9.1	Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9.2	Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9.3	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9.4	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал	8
2.10	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.11	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.12	Шилэн дансны мэдээлэл	9
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Менежментийн захидал	11
3.1	«management_zurchil1»	Error! Bookmark not defined.
3.2	«management_zurchil2»	Error! Bookmark not defined.
4	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	14
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	14
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	15
4.3	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..	Error! Bookmark not defined.
4.4	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	17
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	19

1 Аудитын гэрчилгээ



АЙМГИЙН МУЗЕЙН ЗАХИРАЛ
А.АЙШАГҮЛ ТАНАА

**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий сум, Баян-Өлгий аймаг,

Утас/факс: 70422954, 70422930

2017.09.16 № 8 БМ. 007/152/197-ТМЗ

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Музейн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон, жилийн эцсийн санхүүгийн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1-д заасан бүрэн эрхийн дагуу УАГ-ын харьяа Баян-Өлгий аймгийн Аудитын газраас аудит хийв.

Төсвийн захирагч нь тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллага нь жилийн эцсийн санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Музейн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулга материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн.

Зөрчилгүй санал дүгнэлт

Музейн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.ХУАНГАН

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Музейн захирал А.Айшагул танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж, оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15.2-д заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1 дах заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Аймгийн Музейн 2016 он оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг төлөвлөлтийн шатанд боловсруулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аймгийн Музейн 2016 он оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төр, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017 оны 02-р сарын 12-наас 2017 оны 02-р сарын 15-ны хооронд хийж, аудитын тайланг 2017 оны 02-р сарын 16-нд эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Аймгийн аудитын газрын аудитор Х.Еркебулан хариуцаж хэрэгжүүлэв.

Аймгийн Музейн 2016 он оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа 2017 оны 01-р сарын 07-ны өдөр төрийн аудитын байгууллагад 2017 оны 01-р сарын 07-ны өдөр №04–р албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудит хийхэд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж – Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлав.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид Аудитын олон стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Аймгийн Музей *“Түүх соёлын өвийг хадгалан хамгаалах, баяжуулах, хойч үедээ түгээн дэлгэрүүлэхэд оршино” гэсэн эрхэм зорилгын дор* Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд дараах үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

Аймгийн Музей хуулиар тогтоосон чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээнд өөрийн эрхлэх асуудал, үйл ажиллагааныхаа чиглэл, цар хүрээг дараах байдлаар тодорхойлж баталгаажуулжээ. Үүнд:

Тайлант хугацаанд Аймгийн Музейн *“Сан хөмрөгийг баяжуулах, өөрийн орлого болон үзэгчдийн тоог нэмэгдүүлэх, үзэгчдэд соёлтой болон хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх”* зорилт дэвшүүлэн ажиллажээ.

Аймгийн Музейн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-Б-2.1 маягтаар баталгаажуулсан болно.

Аймгийн Музейн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Соёлын өвийг хамгаалах тухай хууль, музейн стандарт, дүрэм журамууд болон НББ-ийн тухай хуулийг өдөр тутмын ажилд мөрдөж байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Музейн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэж байгаа.

Музейн санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд санхүүгийн “Accolous” програм хангамж ашиглажээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аймгийн Музейн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулъя.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 12 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.6 маягтад нэгтгэж, баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 7 асуудал эрсдэл өндөр, 3 асуудал эрсдэл дунд, 0 асуудал эрсдэл бага гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-В-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 27 байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл өндөр буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй 10 асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих – шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь төлөвлөөлтийн шатанд сонгосонтой холбоотой юм.

Аймгийн Музейн 2016 он оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 202.9 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь 4.0 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа. Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар сонгосон нь эрсдэлийн үнэлгээний түвшинтэй холбоотой юм.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 6 чиглэлээр 12 эрсдэлтэй асуудалд 12 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүн, нөхцөл байдлыг үнэлэхэд хэрэгжүүлсэн нийт горим сорилын 8 хувь буюу 1 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-В-4.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, баримтжуулав.

Алдаа зөрчилтэй буюу буруу илэрхийллийн нэгтгэлээс аудитын явцад залруулах боломжтой эсэх асуудлыг ТАБ-СТА-В-4.3 маягтад шийдвэрлэж, залруулах боломжтой асуудал буюу залруулгын талаарх мэдээллийг ТАБ-СТА-В-4.4, ТАБ-СТА-В-4.5 маягтуудад нэгтгэж, баримтжуулсан.

Харин санхүүгийн тайлан, тодруулга дах залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараах байдлаар ангилав.

(Сая төгрөгөөр)

№	Буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг ангилсан байдал	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж болгосон асуудал	1	4.8	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0	
3	Албан шаардлага өгсөн	0	0	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0	
	Дүн	1	4.8	

Дээрх зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүй жагсаалтыг ТАБ-СТА-В-4.6.1-5 маягтад нэгтгэн баримтжуулав.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Зөвлөмж болгохоор шийдвэрлэсэн буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 3 дугаар бүлгийн Менежементийн захидалд холбогдох зөвлөмжийн хамт оруулав.

Харин бусад материаллаг буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн байдлаар дараах заалтад ангилан харуулав.

2.9.1 Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал

Акт тогтоох зөрчилтэй асуудал гараагүй.

2.9.2 Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал

Албан шаардлага зөрчилтэй асуудал гараагүй.

2.9.3 Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал

Байгууллагын нягтлан бодогчид хариуцлагаа тооцуулахаар санал оруулсан.

2.9.4 Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал

Хууль хяналтын байгууллагад шилжүүлэх алдаа, зөрчилтэй асуудал илэрээгүй.

2.10 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Өөрийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт

2.11 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Аймгийн Музейн өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал зардалд 158,8 сая төгрөгийн төсөв баталсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

/Сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	158,8	163,6	103.0%	4,8
1.1	Урсгал зардал	158,8	163,6	103,0%	4,8
1.2	Хөрөнгийн зардал	0	0	0.0%	0.0
1.3	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	0	0	0.0%	0.0
2	Зардлыг сахуужүүлэх эх үүсвэр	158,8	163,6	103,0%	4,8
2.1	Улсын төсвөөс санхүүжих	156,8	156,8	100,0%	0,0
2.2	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих				
2.3	Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос	2,0	6,8	240,0%	4,8

Төсөвт зардлын гүйцэтгэл 103.0 хувь байгаа нь өөрийн орлогын төлөвлөгөөнөөс давсан хэсгийг зарцуулсантай холбоотой байна.

Тайлант хугацаанд төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний биелэлт 154.9 хувь буюу 1.0 сая төгрөгөөр давуулан биелүүлж төвлөрүүлэн шилжүүлсэн байна.

Тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн дансаар санхүүжилт аваагүй байна. Дээрх зардлыг санхүүжүүлсэн эх үүсвэрийг ангилал тус бүрээр нэмэлт төсвийн тайлангаар баримтжуулан баталгаажуулав.

2.12 Шилэн дансны мэдээлэл

Аймгийн Музейн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно. Шилэн дансны хуультай

холбоотой байж болох эрсдэлийн хүчин зүйлсийг судлах явцад эрсдэлтэй асуудал тогтоогдоогүй.

2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Аймгийн Музейн 2016 он оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Аймгийн Музейн 2016 он оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг энэ тайлангийн 2.8-д нэгтгэн тусгасан бөгөөд эдгээр буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчлийн дүн материаллаг байдлын түвшингээс бага байгаа тул аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналийн бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Аймгийн Музейн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдолтойгоос нь эхлэн эрэмбэлэн үзүүлэв.

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

3.1 Асуудал 1: Өөрийн орлого	3.2 Тэргүүлэх ач холбогдол №1
-------------------------------------	--------------------------------------

БӨ АГ-ын ажиглалт

Байгууллагын туслах үйл ажиллагаанаас орсон 4.8 сая төгрөгийн орлогыг жижиг мөнгөн санд хүлээн авч, зохих зөвшөрөлгүйгээр зарцуулж, батлагдсан төсөвт тусгагдаагүй зарлага гаргаж Төсвийн тухай хуулийн 41.2.2, 47.1.5 дахь заалт болон Төсөвт байгууллагын мөнгөн кассын үйл ажиллагааны журмын холбогдох заалтуудыг зөрчсөн байна.

БӨ АГ-ын зөвлөмж

Төсвийн тухай хуулийн 41.2.2-ийн “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, 47.3-т “энэ хуулийн 47.1.5-д заасан орлогыг зөвхөн батлагдсан төсвийн хүрээнд зарцуулна”, Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмын 2.6-д “Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаанаас орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг /түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй/ ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана” гэсэн заалтуудыг баримталж, өөрийн орлогыг зохих зохих хууль журмын дагуу зарцуулах, зөрчил дутагдлыг дахин давтан гаргуулахгүй байх арга хэмжээ авч ажиллах

Эрсдэлүүд

Төсөвт тусгагдаагүй зарлага гаргах, өөрийн орлогыг төрийн сангийн нэгдсэн зохицуулалтаас гадуур зарцуулах эрсдэлтэй /Иж бүрэн байх, Толилуулга ба тодруулга, Үнэн зөв/

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрч дараах саналыг ирүүлсэн байна.



**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
МУЗЕЙ**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг, Ш. Ногойн гудамж,
Утас/Факс: (976) 7042-2906,
E-mail: bayanolgii_museum@monheritage.mn

2017.02.16 № 20

танай _____-ны № _____

Г

Г

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

2016 оны Музейн туслах үйл ажиллагаанаас орсон 4,8 сая төгрөгийн орлогыг жижиг мөнгөн санд хүлээн авч, зохих зөвшөөрөлгүйгээр зарцуулж Төсвийн тухай хуулийн 41.2.2, 47.1.5 дахь заалт болон төсөвт байгууллагын мөнгөн кассын үйл ажиллагааны журмыг тус тус зөрчсөнийг хүлээн зөвшөөрч байгаа тул цаашид уг зөрчил дутагдалыг дахин давтан гаргахгүй ажиллах болно.

ЗАХИРАЛ  А.АЙШАГУЛ



4 Аудит хийсэн САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**4.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	6227941.00	6227941.00
35	БАРАА МАТЕРИАЛ	6227941.00	6227941.00
354	Хангамжийн материал	6227941.00	6227941.00
35410	Бичиг хэргийн материал	3387500.00	3387500.00
35420	Аж ахуйн материал	1980441.00	1980441.00
35430	Сэлбэг хэрэгсэл		
35440	Түлш, шатах тослох материал		
35450	Барилгын засварын материал		
35460	Хүнсний материал		
35470	Бусад хангамжийн материал	860000.00	860000.00
35500	Биологийн хөрөнгө		
35600	Мал амьтад		
36	НӨӨЦИЙН БАРАА	0.00	0.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2273915770.05	2237830930.79
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2273915770.05	2237830930.79
391	Газар		
392	Биет хөрөнгө	2273617853.20	2237588013.90
39201	Барилга, байгууламж, орон сууц	1207060000.00	1207060000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-496127758.02	-516245424.66
39203	Авто-тээврийн хэрэгсэл	27980000.00	27980000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-9299444.42	-13962777.74
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	64181964.98	68181964.98
39206	Хуримтлагдсан элэгдэл	-26858157.01	-39990644.01
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	35528313.00	36982513.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-9424415.33	-12994967.67
39209	Зам, гүүрийн байгууламж		
39210	Хуримтлагдсан элэгдэл		
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж		
39212	Хуримтлагдсан элэгдэл		
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	1476877350.00	1476877350.00
39214	Бусад үндсэн хөрөнгө		
39215	Хуримтлагдсан элэгдэл		
39216	Дуусаагүй барилга, байгууламж		
39217	Ном	3700000.00	3700000.00
393	Биет бус хөрөнгө	297916.85	242916.89
39301	Програм хангамж	550000.00	550000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-252083.15	-307083.11
39303	Бусад биет бус хөрөнгө		
39304	Хуримтлагдсан элэгдэл		
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2280143711.05	2244058871.79
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1898702.00	0.00

41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1898702.00	0.00
413	Өглөг	1898702.00	0.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1898702.00	
41330	Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг		
41340	Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг		
41350	Зээлийн хүүгийн өглөг		
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2278245009.05	2244058871.79
51	Засгийн газрын хувь оролцоо	2278245009.05	2244058871.79
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	338756626.00	338756626.00
51101	Өмч: - төрийн	338756626.00	338756626.00
51102	- хувийн		
51103	- хувьцаат		
51104	Халаасны хувьцаа		
51105	Нэмж төлөгдсөн капитал		
51106	Эздийн өмчийн бусад хэсэг		
512	Хуримтлагдсан үр дүн	-25712332.95	-59898470.21
51210	Өмнөх үеийн үр дүн	-25712332.95	-25712332.95
51220	Тайлант үеийн үр дүн		-34186137.26
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс		
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1965200716.00	1965200716.00
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга		
51600	Нөөцийн сан		
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2280143711.05	2244058871.79

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	187290450.00	168754100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6060650.00	7951800.00
120	Нийтлэг татварын бус орлого	6060650.00	7951800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6060650.00	7951800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6060650.00	3099000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		4852800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	181229800.00	160802300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	163429800.00	156802300.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	3000000.00	
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	160429800.00	156802300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	15800000.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15800000.00	

1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2000000.00	0.00
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	2000000.00	
1330	Төсвийн захирагчдаас	0.00	4000000.00
133003	Хөрөнгийн		4000000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	206485735.35	202940237.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	206485735.35	202940237.26
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	196352195.35	200057237.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	92876700.00	92876700.00
210101	Үндсэн цалин	92876700.00	92876700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10216500.00	10216500.00
210201	Тэтгэврийн даатгал	10216500.00	10216500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46752262.00	45203021.00
210301	Гэрэл, цахилгаан	1011272.00	2593076.00
210302	Түлш, халаалт	44978600.00	41827945.00
210303	Цэвэр, бохир ус	762390.00	782000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2897855.00	3433122.00
210401	Бичиг хэрэг	628835.00	961100.00
210402	Тээвэр, шатахуун	518600.00	437400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	433530.00	904200.00
210404	Ном, хэвлэл	156400.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1160490.00	1130422.00
2105	Нормативт зардал	161500.00	70200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	161500.00	70200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	847100.00	1101770.00
210602	Тавилга	273100.00	
210604	Урсгал засвар	574000.00	1101770.00
2107	Томилолт, зочны зардал	2590200.00	867415.00
210702	Дотоод албан томилолт	2590200.00	867415.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	287525.00	4749470.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		4057870.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		224000.00
210803	Даатгалын үйлчилгээ	214395.00	320100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		95000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33000.00	3000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	40130.00	49500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39722553.35	41539039.26
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1010320.00	
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	38712233.35	41539039.26
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10133540.00	2883000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	6526560.00	1784000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	5097000.00	

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1429560.00	1784000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3606980.00	1099000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3606980.00	1099000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-19195285.35	-34186137.26
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-19195285.35	-34186137.26

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-3А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	168490450.00	164754100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6060650.00	7951800.00
120	Нийтлэг татварын бус орлого	6060650.00	7951800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6060650.00	7951800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6060650.00	3099000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		4852800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	162429800.00	156802300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	160429800.00	156802300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	160429800.00	156802300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2000000.00	0.00
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	2000000.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	165660800.00	163299900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	165660800.00	163299900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	155527260.00	160416900.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	92876700.00	92876700.00
210101	Үндсэн цалин	92876700.00	92876700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10216500.00	10216500.00
210201	Тэтгэврийн даатгал	10216500.00	10216500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44853560.00	47101723.00
210301	Гэрэл, цахилгаан	905310.00	2699038.00
210302	Түлш, халаалт	43185860.00	43620685.00
210303	Цэвэр, бохир ус	762390.00	782000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2898755.00	3402922.00
210401	Бичиг хэрэг	610830.00	961100.00
210402	Тээвэр, шатахуун	518600.00	437400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	433530.00	904200.00
210404	Ном, хэвлэл	156400.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1179395.00	1100222.00

2105	Нормативт зардал	161500.00	70200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	161500.00	70200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	633100.00	1101770.00
210602	Тавилга	273100.00	
210604	Урсгал засвар	360000.00	1101770.00
2107	Томилолт, зочны зардал	2590200.00	867415.00
210702	Дотоод албан томилолт	2590200.00	867415.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	286625.00	4779670.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		4088070.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		224000.00
210803	Даатгалын үйлчилгээ	214395.00	320100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		95000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33000.00	3000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	39230.00	49500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1010320.00	0.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1010320.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10133540.00	2883000.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	6526560.00	1784000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	5097000.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1429560.00	1784000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3606980.00	1099000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3606980.00	1099000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	2829650.00	1454200.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	2829650.00	1454200.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2829650.00	1454200.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2829650.00	1454200.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2829650.00	1454200.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-2829650.00	-1454200.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

4.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл				0.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайлант үеийн үр дүн	338,756,626.00	1,965,200,716.00	-25,712,332.95	2,278,245,009.05
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	338,756,626.00	1,965,200,716.00	-25,712,332.95	2,278,245,009.05
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	338,756,626.00	1,965,200,716.00	-25,712,332.95	2,278,245,009.05
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	338,756,626.00	1,965,200,716.00	-25,712,332.95	2,278,245,009.05
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн			-34,186,137.26	-34,186,137.26
D09	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	338,756,626.00	1,965,200,716.00	-59,898,470.21	2,244,058,871.79

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	158802300.00	163655100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	158802300.00	163655100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	158802300.00	161871100.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	92876700.00	92876700.00
210101	Үндсэн цалин	92876700.00	92876700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10216500.00	10216500.00
210201	Тэтгэврийн даатгал	10216500.00	10216500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46827600.00	47101723.00
210301	Гэрэл, цахилгаан	2678400.00	2699038.00
210302	Түлш, халаалт	43367200.00	43620685.00
210303	Цэвэр, бохир ус	782000.00	782000.00
210304	Байрны түрээс		
2104	Хангамж, бараа материалын зардал	2013700.00	3402922.00
210401	Бичиг хэрэг	598200.00	961100.00
210402	Тээвэр, шатахуун	437400.00	437400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	452000.00	904200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	526100.00	1100222.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
2105	Нормативт зардал	250200.00	250200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	250200.00	250200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	706300.00	1829740.00
210602	Тавилга		371000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		
210604	Урсгал засвар	706300.00	1458740.00
2107	Томилолт, зочны зардал	585400.00	867415.00
210702	Дотоод албан томилолт	585400.00	867415.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5325900.00	5325900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4634300.00	4634300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	224000.00	224000.00
210803	Даатгалын үйлчилгээ	320100.00	320100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	95000.00	95000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	3000.00	3000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	49500.00	49500.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	1784000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	1784000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		1784000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	158802300.00	163655100.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	156802300.00	156802300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	156802300.00	156802300.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2000000.00	6852800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2000000.00	2000000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		4852800.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	16.00	16.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	7.00	7.00
620003	Үйлчлэх ажилтан	8.00	8.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	16.0	16.0
650006	Соёл урлагийн салбарын терийн йлчилгээний албан хаагч (ТҮСУ)	6.00	6.00
650009	Терийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	10.00	10.00

АУДИТЫН ТАЙЛАНГ:**ХЯНАСАН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.ХУАНГАН

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.ЖЕНИСБЕК

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Х.ЕРКЕБУЛАН

Огноо: 2017.02.15